



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 120

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 16 ангиллын, 5506 ширхэг, нийт 22,362,531,852.07 (хорин хоёр тэрбум гурван зуун жаран хоёр сая таван зуун гучин нэгэн мянга найман зуун тавин хоёр төгрөг долоон мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглаж болох хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 1,906,809,939.46 (нэг тэрбум есөн зуун зургаан сая найман зуун есөн мянга есөн зуун гучин есөн төгрөг дөчин зургаан мөнгө) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, "Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ү.Төмөрхуяг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001281
9-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн
110 дугаар тогтоолын хавсралт

"ДУЛААНЫ ДӨРӨВДҮГЭЭР ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ҮЛДЭХ
ӨРТӨГГҮЙ, АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАЖ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ТОВЧОО

Д/д	Хөрөнгийн ангилал	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоосон нэг бүрийн үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон нэг нийт үнэ (төгрөг)
1	Бусад ерөнхий хэрэглээний үндсэн хөрөнгө	6	60,122,738.63	60,122,738.63	1,803,682.16	1,803,682.16
2	Бусад техник хэрэгсэл	5	36,807,861.43	36,807,861.43	3,357,842.02	3,357,842.02
3	Засварын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл	467	7,372,134,739.64	7,372,134,739.64	698,900,060.59	698,900,060.59
4	Зуухны тоног төхөөрөмж	8	680,199,676.55	680,199,676.55	20,405,990.30	20,405,990.30
5	Компьютерийн программ хангамж	27	2,119,241,803.74	2,119,241,803.74	386,293,506.50	386,293,506.50
6	Компьютер, түүний дагалдах хэрэгсэл	750	1,627,354,350.95	1,627,354,350.95	231,536,004.45	231,536,004.45
7	Лабораторийн тоног төхөөрөмж	119	1,642,008,973.19	1,642,008,973.19	177,044,151.33	177,044,151.33
8	Тавилга эд хогшил	3691	1,668,064,787.93	1,668,064,787.93	75,271,624.39	75,271,624.39
9	Түлш агуулах, боловсруулах хэрэгсэл	47	71,984,262.42	71,984,262.42	7,200,567.80	7,200,567.80
10	Түлш дамжуулах тоног төхөөрөмж	59	1,652,156,321.46	1,652,156,321.46	52,227,683.93	52,227,683.93
11	Тээврийн хэрэгсэл	39	3,328,842,686.32	3,328,842,686.32	141,728,483.54	141,728,483.54
12	Усан сан, далан, ус дамжуулах төхөөрөмж	5	32,361,517.62	32,361,517.62	1,034,614.42	1,034,614.42
13	Ус боловсруулах системийн тоног төхөөрөмж	1	5,384,905.10	5,384,905.10	161,547.15	161,547.15
14	Холбооны тоног төхөөрөмж	232	437,600,020.38	437,600,020.38	50,377,521.28	50,377,521.28
15	Цахилгаан станцын бусад тоног төхөөрөмж	45	1,608,139,854.18	1,608,139,854.18	56,731,988.89	56,731,988.89
16	Цахилгаан тоног төхөөрөмж	5	20,127,352.53	20,127,352.53	2,734,670.71	2,734,670.71

Д/д	Хөрөнгийн ангилал	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоосон нэг бүрийн үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон нэг нийт үнэ (төгрөг)
		5506		22,362,531,852.07		1,906,809,939.46
	Нийт дүн			(хорин хоёр тэрбум гурван зуун жаран хоёр сая таван зуун гучин нэгэн мянга найман зуун тавин хоёр төгрөг долоон мөнгө)		(нэг тэрбум есөн зуун зургаан сая найман зуун есөн мянга есөн зуун гучин есөн төгрөг далан нэгэн мөнгө)

